



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/85

Баянтал сум

Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам”, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 3 (гурав) нэгж талбарыг малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг 2024 оны 06 дугаар сарын 12-ний өдөр зарлаж, төслийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 12:00 цаг хүртэл хүлээн авах ажлыг газрын биржийн цахим системээр зохион байгуулахыг Газрын даамлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (О.Энхзул)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Хишигням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ГАНБАЯР

Сумын Засаг даргын 2024 оны 06
дугаар сарын 11 -ны өдрийн A/28
дугаар захирамжийн хавсралт

**ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ШИЙДВЭРЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ,
ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ЭЗЭМШҮҮЛЭХ ХУГАЦАА**

№	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Хэмжээ м.кв (га)	Зориулалт	Эзэмшүүлэх хугацаа
1	4092190	16-р зөрлөгийн зүүн урд талд	5	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт	15 жил
2	4106379	Цэргийн ангийн зүүн талд	5	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт	15 жил
3	4110976	16-р зөрлөгөөс зүүн урагш	0,3	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалт	15 жил



ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/85 дугаар захирамжийн дагуу газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах тул сонирхсон малчдын хоршоог оролцохыг урьж байна.

Төсөл сонгон шалгаруулалтын материалыг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 25-ны өдрийн 12 цаг хүртэл Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар хүлээн авна.

Улсын тэмдэгтийн хураамж тушаах данс: 100220400941

ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАЖ БУЙ ГАЗРУУДЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Эзэмшүүлэх газрын байршил	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м ² /	Газар эзэмших хугацаа /жил/	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Улсын тэмдэгтийн хураамж
1	16-р зөрлөгийн зүүн урд талд	Мал аж ахуйн үйлдвэрлэл	50000	15	4092190	12500
2	Цэргийн ангийн зүүн талд	Мал аж ахуйн үйлдвэрлэл	50000	15	4106379	12500
4	16-р зөрлөгөөс зүүн урагш	Мал аж ахуйн үйлдвэрлэл	3000	15	4110976	12500

“Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалттай газар”-т дараах зориулалтаар төсөл бичнэ.

Үүнд:

- ✓ мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ эрхлэх
- ✓ мал эмнэлгийн үйлчилгээ
- ✓ малын бордоо бэлтгэх үйл ажиллагаа
- ✓ тэжээлийн үйлдвэрлэлийн цех
- ✓ хөдөө аж ахуйн зориулалттай барилга байгууламж барих
- ✓ эрчимжсэн мал аж ахуйн ферм
- ✓ мал нядалгаа
- ✓ гахай, шувуу, зөгий, цаа бугын аж ахуйн ферм
- ✓ малын гаралтай түүхий эд авах цэг, агуулах, зоорь барих
- ✓ малын гаралтай түүхий эд, дайвар болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
- ✓ мах, сүү, цагаан идээ боловсруулах үйлдвэрлэл

Харилцах утас: 7054-3387, 99180283

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

